



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 1/625

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын шинэ суурьшлын бүс дэх "ХАУС ХОРООЛОЛ"-д оршин суугч иргэдийн хэрэгцээнд шинээр угсарсан цахилгаан, дулаан, хэрэглээний цэвэр усны шугам, сүлжээг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүд: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн -Аймгийн ерөнхий архитектор

-“Онги-Ус суваг” ОНӨААТҮГазрын захирал

-“Онги-Ус суваг” ОНӨААТҮГазрын ерөнхий инженер

-“Арвайн илч” ХХК-ийн гүйцэтгэх захирал

-“Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ний

Өвөрхангай аймаг дахь салбарын дарга

-“Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ний Өвөрхангай

аймаг дахь салбарын ахлах инженер

- “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГазрын захирал

- “ХАУС ХОРООЛОЛ” төслийн нэгжийн менежер, инженер

-“Монголын цахилгаан холбоо” ТӨХК-ний Өвөрхангай аймаг дахь салбарын захирал

2. Шинээр угсарсан цахилгаан болон дулаан, хэрэглээний цэвэр усны шугам, сүлжээг газар дээр нь нэг бүрчлэн үзэж, стандартын дагуу ашиглалтад хүлээн авах ажлыг сайтар зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101163